

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.03.10

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Монголбанк бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12.0%-д хүргэлээ.
- Премиум Нэксус хк-ийн 2024 оны цэвэр ашиг 48.4 тэрбум төгрөг гарлаа.
- Mongolian Mining Corporation-ийн хувьцаа огцом унав.
- Хөрөнгө оруулагчийн зурхай

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.43%	2.05%	25.47%
MSE A	-0.23%	1.95%	20.27%
MSE B	--1.89%	3.99%	34.89%
2025/03/06 – 2025/03/07			

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	247,600,036.00
MSE	104,890,753.19
LEND	54,474,811.49
TTL	34,603,520.00
APU	32,117,738.26
2025/03/06 – 2025/03/07	

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
SOH	632.00	14.91%
MCH	850.00	14.86%
MBW	190.50	8.85%
KHAN	1,308.00	2.59%
RMC	80.00	2.56%
2025/03/06 – 2025/03/07		

2025 он 03-р сарын 10

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,419

ТОП-20 индекс

52,209

MSE A

20,325

MSE B

15,150



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

4.9%

2024 он

Инфляц

9.6%

2025-01 сар

ГВУН(сая\$)

4,884.28

2025-01 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.92%

USD/MNT

3,467.49

2025-03-09




Дотоодын зах зээлийн мэдээлэл

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ (2025.03.07)



- Монголбанк бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12.0%-д хүргэлээ.
- Банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоов.
- Тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд зээлийн сарын төлбөрөө төлсний дараах зээлдэгчийн үлдэх орлого нь хүн амын амьжиргааны доод түвшнээс доошгүй байхаар тогтоолоо.



ЭДИЙН ЗАСАГТ ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?



Яагаад бодлогын хүү өсөв?

1. Инфляцын өсөлттэй тэмцэх – Инфляц хэт өндөр байх нь худалдан авах чадварыг бууруулж, иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг. Бодлогын хүүг өсгөснөөр мөнгөний нийлүүлэлтийг бууруулж, үнийн өсөлтийг хязгаарлах зорилготой.
2. Төгрөгийн ханшийг тогтворжуулах – Сүүлийн үед төгрөгийн ханш сулрах хандлагатай байна. Хүү өсөх нь гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, валютын ханшийн уналтыг сааруулахад нөлөөлнө.
3. Зээлийн өсөлтийг хязгаарлах – Өндөр хүүтэй орчинд зээлийн эрэлт буурч, хэт халсан зах зээл, хэрэглээг сааруулах зорилготой.

Үр дагавар нь юу вэ?

- Банкны хадгаламжийн хүү өсөх тул хүмүүс хадгаламждаа илүү анхаарах магадлалтай.
- Зээлийн хүү өндөржих учир бизнесүүдийн хөрөнгө оруулалт, хэрэглэгчдийн зээлийн эрэлт буурах хандлагатай.
- Инфляц буурч, бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжих боломжтой.



Дотоодын зах зээлийн мэдээлэл

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН 2024 ОНЫ ЦЭВЭР АШИГ 48.4 ТЭРБУМ ТӨГРӨГ ГАРЛАА.



МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг Премиум Нэксус ХК-ийн цэвэр ашиг 2024 онд 48.4 тэрбум төгрөгт хүрлээ.

Онцлох үзүүлэлтүүд:

- Салбарын тооны өсөлт: 2024 онд нийт 81 шинэ салбар нээж, нийт 445 салбартай болсон. Үүнээс 397 нь Улаанбаатар хотод, 50 нь орон нутагт байрлах дэлгүүрүүд.
- Шинэ амжилт: Монгол Улсын ТОП 100 ААН-ийн эрэмбээ ахиулж 8-р байранд шалгарлаа.
- Ашиг өсөв: Компанийн цэвэр ашиг 2024 оны жилийн эцэст 48.4 тэрбум төгрөг буюу 8.1 хувийн цэвэр ашгийн маржинтай гарсан. Нийт ашгийн дүнд Чингис шар айргийн 19.4 тэрбум төгрөгийн нэг удаагийн бизнес нэгдлийн олз орсон болно.
- Дэлхийн жишигт нийцсэн чанар: CU хоолны үйлдвэр нь нийт 5 MNS & ISO стандартыг баталгаажуулсан анхны хоол үйлдвэрлэлийн байгууллага боллоо.

График 1. Нийт цэвэр борлуулалт (тэрбум төгрөг)




График 2. Цэвэр ашиг (тэрбум төгрөг)





График 3. Нийт дэлгүүрийн тоо



MONGOLIAN MINING CORPORATION-ИЙН ХУВЬЦАА ОГЦОМ УНАВ.

Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Mongolian Mining Corporation (MMC) компанийн хувьцааны үнэ 8.4%-иар унаж, 6.10 хонконг долларт хүрэв. Энэ нь 2023 оны 12 сараас хойших хамгийн доод түвшин юм.

Хувьцааны уналтын шалтгаан:

- Засгийн газрын ажлын хэсэг "Ухаа худаг"-ийн нүүрсний ордын тусгай зөвшөөрлийг хууль зөрчиж шилжүүлсэн гэж дүгнэжээ.
- Хууль зүйн сайд уг зөвшөөрлийг хүчингүй болгох тогтоолын төслийг УИХ-д өргөн барихаар төлөвлөж буйгаа мэдэгдсэн.

MMC-ийн байр суурь: MCS группийн Ерөнхийлөгч Ж.Оджаргал "Тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу авсан" гэж мэдэгдсэн.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Симбол	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ
1	Дархан нэхий ХК	NEH	2025-03-10	0.226
2	Багануур ХК	BAN		23.62
3	Барилга корпораци ХК	BRC	2025-03-11	100
4	Хас Банк	XAC		27
5	Төрийн Банк ХК	SBM		63.70
6	Хаан банк ХК	KHAN		195.35
7	Материалимпекс ХК	MIE		150
8	Инвескор ББСБ ХК	INV		60
9	Айтүүлс ХК	ITLS		3.5
10	Мандал Даатгал ХК	MNDL		8.10
11	Улаанбаатар хивс ХК	UBH	2025-03-15	2000
12	Голомт Банк ХК	GLMT		100
13	Сүү ХК	SUU		3.43
14	Таван толгой ХК	TTL		6960
15	Эм Жи Эл Акуа ХК	MGLA	2025-02-25	7.31
16	Гутал ХК	GTL	2025-03-31	2470
17	АПУ ХК	APU		65
18	Инновэйшн инвестмент ХК	QPAY		20
19	Монложистикс Холдинг ХК	MLG		5.4
20	Талх чихэр ХК	TCK		450
21	Би ди сек ХК	BDS		89.67
22	Сэндли ББСБ ХК	SEND	2025-03-15	7.61
23	Монгол Базальт ХК	MBW		2.42
24	Баянгол зочид буудал ХК	BNG		330
25	Тэнгэр Даатгал ХК	TGI		67.12
26	Монос хүнс ХК	MFC	2025-03-12	4
27	Газар Шим Үйлдвэр ХК	GAZR	2025-03-10	2.6
28	Улаанбаатар БҮК ХК	BUK		10
29	Хүрд ХК	HRD		8
30	Тандэм инвэст ББСБ ХК	TAND		1.1
31	Бодь Даатгал ХК	BODI		5
32	Махимпекс ХК	MMX		100
33	Монгол шуудан ХК	MNP		1
34	Монголын хөрөнгийн бирж ХК	MSE		47
35	Гермес центр ХК	HRM	2025-03-07	9.60
36	ЛэндМН ББСБ ХК	LEND	2025-02-26	15
37	Эрдэнэт Суврага ХК	SVR	2025-02-26	5

T+2 төлбөрийн тооцооны системийн дагуу явдаг учир бүртгэлийн өдрөөс 2 өдрийн өмнөх эзэмшлээс тооцдог болохы анхаарна уу

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЗУРХАЙ



Хонь: (3/21–4/19)

Өсөлтийг эрхэмлэгчид

Эрсдэлд дуртай, хурдан ашиг хайгч. Хэлбэлзэл ихтэй хувьцаа, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт тохиромжтой. Томоохон өсөлтөд зоригтой хөрөнгө оруулалт хийдэг.



Үхэр: (4/20–5/20)

Найдвартай, хариуцлагатай

Урт хугацааны ашиг, бага эрсдэлийг чухалчилдаг. Судалгаанд тулгуурлаж шийдвэр гаргадаг. Санхүүгийн зорилгодоо хүрэхийн тулд урт хугацаанд бага багаар хөрөнгө оруулдаг.



Ихэр: (5/21–6/20)

Сониуч, эрсдэлд дурлагсад

Сониуч зандаа хөтлөгдөж өндөр эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхээс айдаггүй. Хөрөнгө оруулалтаа төрөлжүүлж, алдагдлаас сэргийлэх шаардлагатай. Богино хугацаанд ашиг хайх нь эрсдэлтэй.



Мэлхий: (6/21–7/22)

Арыг нь даах хуримтлалыг эрхэмлэгчид

Хуримтлал, санхүүгийн аюулгүй байдлыг чухалчилж урт хугацааны тогтвортой өсөлтөд төвлөрдөг. Хөрөнгийн багцаа төрөлжүүлэхийн тулд бага зэрэг туршилт, эрсдэл хийх нь зайлшгүй чухал.



Арслан: (7/23–8/22)

Том мөрөөдөлтэй, зоригтой Шинийг санаачлагч, урт хугацааны ашигт анхаардаг. Бизнес санаа хэрэгжүүлэхдээ хөрөнгө босгохоос эмээдэггүй.



Охин: (8/23–9/22)

Судалгаанд суурилсан, нягт төлөвлөгч.

Логик сэтгэлгээгээр хөрөнгө оруулалт хийдэг ч шийдвэр гаргахад удаан. Тодорхой хэсгийг нийгмийн сайн сайхны төлөө зарцуулдаг.



Жинлүүр: (9/23–10/22)

Тэнцвэрийг эрхэмлэгчид

Тансаг хэрэглээнд дуртай. Санхүүгийн сахилга баттай байх хэрэгтэй. Гэнэтийн нөхцөл байдалд бэлэн мөнгөний нөөц бүрдүүлдэг. Үүний дараа илүү ашигтай хөрөнгө оруулалтын боломжуудыг судалж эхлэх нь зүйтэй.



Хилэнц: (10/23–11/21)

Дүрэмд баригдалгүй хөрөнгө оруулдаг нууцлаг хүмүүс

Зах зээлийг сайтар судалж, зөн совиндоо итгэдэг. Ашиг олохдоо тайван, хянуур ханддаг. Өөрсдийн санхүүгийн нууцыг бусадтай хуваалцах нь ховор.



Нум: (11/22–12/21)

Санхүүгийн эрх чөлөө, хөгжил дэвшилд татагддаг

Тогтмол хөрөнгө оруулалтаар урт хугацааны өсөлтийг эрхэмлэдэг. Эрсдэлтэй зах зээлд болгоомжтой ханддаг. тогтмол хөрөнгө оруулах дадал бий болгосныхоо дараа өөрсдийн хөрөнгө оруулалтыг илүү амжилттай удирдаж чаддаг.



Матар: (12/22–1/19)

Тогтвортой, сахилга баттай

Эрсдэл багатай, төрөлжүүлсэн хөрөнгө оруулалтыг чухалчилдаг. Ирээдүйгээ ухаалаг төлөвлөдөг.

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК-ИЙН САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДУУД

ДУНДАЖ ӨГӨӨЖ

18.0%-20.0%

Бондын төрөл	Хаалттай бонд	Нээлттэй бонд	ХБҮЦ
Дундаж хүү	18.0% - 19.0%	17.5% - 18.0%	18.00%
Татвар	10.0%	5.0%	5.0%
Татварын дараах өгөөж	16.2% - 18%	16.6% - 17.1%	16.15%-17.1%
Хугацаа	12-24 сар	12-24 сар	12-24 сар
Барьцаа	Үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, хөндлөнгийн баталгаа, хөдлөх хөрөнгүүд (>130%)		Авлагын мөнгөн урсгал (>110%)

Тэмдэглэл: Хүү болон өгөөжийн түвшин 2025 оны 1 сарын байдлаар

БОГИНО ХУГАЦААТ БОНДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХУГАЦАА	ХҮҮГИЙН ХУВЬ
1 сар	12%
2 сар	13%
3 сар	14%
4 сар	15%
5 сар	16%
6 сар	17%



Аж ахуйн нэгжүүдэд зориулан тогтмол хугацаанд байгууллагын мөнгөн урсгалд нийцсэн хөрөнгө оруулалт хийх боломжтой.

АМ.ДОЛЛАРЫН БОНД

БОНДЫН ТӨРӨЛ	ӨГӨӨЖ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД	5.34%-6.5%
КОМПАНИЙН БОНД	6.8%-9.5%

БОГИНО ХУГАЦААТ АМ.ДОЛЛАРЫН БОНД

БОГИНО ХУГАЦААТ БОНД	ӨГӨӨЖ /ЖИЛИЙН/
1 САР	3%
2 САР	4%
3 САР	5%
4+ САР	БРОКЕРТОЙ ХОЛБОГДОНО УУ
ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН БАТАЛГАА ГАРГАГЧ	ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

БОНДЫН ЗАХИАЛГА ӨГӨХ

Төгрөгийн бонд: 8665-1177 | 8665-4422 | 8083-6622 | 8888-9183
Долларын бонд: 8083-6622 | 8888-9183



Хумх: (1/20–2/18)

Инновац, нийгмийн төсөлд хөрөнгө оруулдаг. Өглөгч зангаасаа болж эрсдэл хүлээх магадлалтай. Мэргэжлийн зөвлөгчтэй ажиллах нь үр дүнтэй.



Загас: (2/19–3/20)

Урт хугацааны хөрөнгө оруулалтыг эрхэмлэгч.

Хэт гэнэн байдал, богино хугацааны ашиг хайхаас зайлсхийх хэрэгтэй. Санхүүгийн удирдлагад мэргэжлийн тусалцаа шаардлагатай.